

2006 оны 2 дугаар сар

## Холбогдох байгууллагууд дорвитой арга хэмжээ авахгүй, хотын агаар бохирдсоор байна



Нийслэлийн агаарын бохирдлыг багасгах талаар холбогдох байгууллагаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тэдгээрийн үр нөлөө

## Агуулга

Ерөнхий зүйл	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	1
	Аудитын талаархи ерөнхий ойлголт	1
	Аудитад ашигласан шалгуур	2
	Аудитын стандартын талаархи мэдэгдэл	2
	Аудит хийх явцад гарсан хүндрэл бэрхшээл	3
Аудитын дүн	Агаарын бохирдлын шалтгаан, судалгааны үр дүн	4
	Агаар хамгаалахад чиглэгдсэн төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр нөлөө	8
	Агаарын талаархи хууль тогтоомжийг Засгийн газрын болон нийслэлийн төр, захиргааны байгууллагууд мөрдөж буй байдал	10
	Агаарын бохирдлыг багасгахад зориулсан төсөв, хөрөнгийн хүрэлцээ, зарцуулалт	15
Дүгнэлт		16
Холбогдох байгууллагын санал		18
Зөвлөмж		20
Хавсралт	Хавсралт	22

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Үндэсний аудитын газрын 2005 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд **Засгийн газар болон нийслэлийн төр, захиргааны байгууллагууд хотын агаарын чанарыг хэрхэн үнэлж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэж байгаа байдалд** аудит хийлээ.

Дараахь асуудалд аудит хийж дүгнэлт гарган, үр нөлөөг дээшлүүлэх талаар санал зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ. Үүнд:

- Агаарын бохирдлын шалтгаан, судалгааны үр дүн
- Агаар хамгаалахад чиглэгдсэн төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр нөлөө
- Агаарын талаархи хууль тогтоомжийг Засгийн газрын болон нийслэлийн төр, захиргааны байгууллагууд мөрдөж буй байдал
- Агаарын бохирдлыг багасгахад зориулсан төсөв, хөрөнгийн хүрэлцээ, зарцуулалт

Аудитаар Агаарын тухай хууль болон бусад хууль эрхийн актаар агаарыг хамгаалах, агаарын чанарын хяналт шинжилгээ хийх, энэ талын бодлого боловсруулж, хэрэгжүүлэх үүрэг бүхий яам, агентлаг, байгууллагын үйл ажиллагааг хамруулан шалгав.

Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандартын дагуу холбогдох хүмүүстэй ярилцлага хийх, тайлбар, нотолгоо авах, төсөвт зардлын төлөвлөгөө, гүйцэтгэлийг харьцуулах, түүнийг анхан шатны баримтаар тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг гүйцэтгэлийн болон байгаль орчны аудитын арга зүйг ашиглан хийлээ.

Аудитын талаархи ерөнхий ойлголт

Дэлхийн ихэнх оронд тохиолдож байгаа газрын доройтол, ойн нөөцийн хомсдол, хөрсний элэгдэл, бохирдол, ан амьтны оршиц нутаг устах, хот суурин ба үйлдвэрлэлийн хог хаягдал, **агаарын бохирдол** гэх мэт хүрээлэн буй орчны тулгамдсан асуудлуудаас үүдэн байгаль орчноо хамгаалах шаардлага тулгарч байна.

Үүнд аудитын дээд байгууллагууд анхаарлаа чиглүүлснээр байгаль орчны аудитын төрөл хэлбэр бий болж, энэ талаар нилээд туршлага хуримтлуулжээ.

Монгол Улсын төрийн аудитын байгууллага ч байгаль орчны аудитыг хийж эхлээд тодорхой хугацаа өнгөрсөн байна.

Сүүлийн жилүүдэд манай оронд хүн амын суурьшил, хотжилт, үйлдвэржилт нэмэгдэж, техникийн болон хүний үйл ажиллагаатай холбоотой орчны бохирдол, түүний дотор агаарын бохирдол зөвшөөрөгдөх хэмжээнээс ихэсч, хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд сөргөөр нөлөөлөн, эрүүл, аюулгүй орчинд амьдрах хүний эрх зөрчигдөх болжээ.



Агаарт байдаг үндсэн бохирдуулагчид, эдгээрийн эх үүсвэр, хор хөнөөлийн талаархи мэдээллийг хавсралт №1-д үзүүлэв.

Аудитад  
ашигласан  
шалгуур  
үзүүлэлтүүд  
Аудитын  
стандартын  
талаархи  
мэдэгдэл

Дээрх зорилтыг ханган биелүүлэхэд аудитын хөтөлбөрт тусгагдсан шалгуур үзүүлэлтүүдийг ашиглалаа.

Энэхүү аудитыг хийхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэглэх аргачилсан зөвлөмж, Байгаль орчны аудитын сургалтын материал, гүйцэтгэлийн аудитын болон түүний тайланг хянан баталгаажуулах журам, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Байгаль орчны аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон ажиллалаа.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журам, Байгаль орчны аудитын гарын авлагад заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, судалгаа, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитыг Үндэсний аудитын газрын нэгдүгээр хэлтсийн дарга Д.Ганбилэг удирдаж, тус хэлтсийн болон Нийслэлийн аудитын газрын аудитор, шинжээч нар 2005 оны 12 дугаар сарын 1-нээс 2006 оны 1 дүгээр сарын 15-ныг хүртлэх хугацаанд хийлээ.

Аудит хийх  
явцад гарсан  
хүндрэл  
бэрхшээл

Агаарыг хамгаалах, бохирдлыг бууруулах нь олон салбарыг хамарсан өргөн хүрээтэй асуудал тул энэ талын мэдээ, материал, судалгааг цуглуулах, боловсруулахад цаг хугацааны хувьд шахуу байлаа.

Аудит хийхэд шаардагдах мэдээ тайлан, баримт материалыг холбогдох байгууллагууд тухай бүр гаргаж өгөхгүй олон удаа шаардуулж шалгалтын явцад хүндрэл учруулж байлаа.

Агаарын  
бохирдлын  
шалтгаан,  
судалгааны үр  
дүн

Агаарын чанар, бохирдлын шалтгаан, түүний эх үүсвэрүүдийг үнэн зөв тогтоох нь цаашид энэ талаар баримтлах бодлого, арга хэмжээг оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Агаарын тухай хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар агаарын чанарыг тодорхойлох, хяналт шинжилгээ хийх, холбогдох мэдээ гаргах үүргийг Агаарын чанарын асуудал эрхэлсэн мэргэжлийн алба хариуцан гүйцэтгэх ёстой.

Агаарын чанарын албаны үүргийг Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээнд багтдаг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Ус цаг уур, орчны шинжилгээний газар эрхлэн гүйцэтгэж байна.

Тус алба агаарын чанарын хяналт шинжилгээний сүлжээг мэргэжлийн удирдлагаар хангах, агаарын чанарын тухай мэдээллийг төр засаг, ард иргэд, байгууллагад түгээн зарлах, агаарыг хамгаалах арга хэмжээний шинжлэх ухаан, техникийн бодлого боловсруулан хэрэгжүүлэх үүрэгтэй ажээ.

Агаарын тухай хуулийн 5.1-д зааснаар Байгаль орчны яам агаарын чанар, түүний өөрчлөлтөд байнгын хяналт тавих зорилго бүхий хяналт шинжилгээний сүлжээг зохион байгуулж ажиллуулах ёстой.

Агаарын чанарын хяналт шинжилгээний талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүний үр нөлөөг үнэлэх зорилгоор Ус цаг уур, орчны шинжилгээний газрын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, Байгаль орчны шинжилгээний төв лаборатори зэрэг байгууллага, албан тушаалтнуудаас тэдний үүрэг, зорилготой уялдуулан боловсруулсан асуулга явуулж, дүн шинжилгээ хийлээ.

Агаарын чанарын хяналт шинжилгээг Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлд зааснаар Ус цаг уур, орчны шинжилгээний газрын даргын тушаалаар батлагдсан “Байгаль орчны хяналт шинжилгээний 2000 – 2005 онд хийх ажлын хөтөлбөр”-ийн дагуу холбогдох байгууллагууд хэрэгжүүлж байна.

Дээрх хөтөлбөрт тусгагдсанаар Улаанбаатар хотын агаарын бохирдлыг хянах суурин болон явуулын харуулууд дээр агаар дахь үндсэн бохирдуулагч хүхэрлэг хий ( $\text{SO}_2$ ) азотын давхар исэл ( $\text{NO}_2$ ) угаарын хий ( $\text{CO}$ ), азот ( $\text{NO}$ ), тоосны ( $\text{PM}$ ) агууламжийг тодорхой горимын дагуу тодорхойлж, мэдээлэл хэрэглэгчдэд хүргэж байх ёстой.


Улаанбаатар хотын агаарын чанарын талаархи 2000 – 2005 оны тайлан мэдээ болон холбогдох байгууллага, албан тушаалтнуудаас авсан судалгаанаас үзэхэд Улаанбаатар хотын агаарын бохирдлыг хянах 4 харуулын цэг дээр хүхэрлэг хий ( $\text{SO}_2$ ) болон азотын давхар ислээс ( $\text{NO}_2$ ) гадна тоосны ( $\text{PM}$ ) ажиглалтыг хийж байсан боловч 2004 оноос багаж,



тоног төхөөрөмж эвдэрснээс тоосны (PM) ажиглалт зогссон байна.

Дээрх шалтгааны улмаас бусад харуулууд ч хөтөлбөрийн дагуу ажиглалт, судалгааг бүрэн хийж чадахгүй байна.



Байгаль орчны төв лабораторийн Улаанбаатар хотын агаарын чанарт хийсэн шинжилгээ судалгаанд үндэслэн 2000 оноос хойш хүхэрлэг хий ( $SO_2$ ), азотын давхар ислээс ( $NO_2$ ) гадна тоосны PM агууламжийн хэмжээ хэрхэн өөрчлөгдөж байгааг дараахь графикт үзүүлэв.





Улаанбаатар хотын агаарын бохирдлын түвшин хэрхэн нэмэгдсэн нь агаарт байгаа зөвхөн дээрх бохирдуулагч элементүүдийн агууламжийн өсөлтөөс тодорхой харагдаж байна.

Агаарын бохирдолд ихээхэн нөлөөлж буй бусад бохирдуулагчийн агаар дахь агууламжийг судалж тогтоож байсан бол агаарын бохирдлын хэмжээг илүү бодитой тогтоох боломжтой байжээ.

Агаарын бохирдлыг хянах суурин харуулын болон бохирдуулах эх үүсвэрийн тухай мэдээллийг үндэслэж хүрээлэн буй орчны агаарт буй бохирдуулагчийн бүтэц, агаар бохирдуулах эх үүсвэр бүрийн хэмжээ, нөлөөллийг тогтоодог.

Эдгээр үзүүлэлтийг оновчтой тогтооход математик загварчлалын аргаас гадна иж бүрэн туршилт хийх боломжтой.



Иж бүрэн туршилт хийснээр агаар бохирдуулж буй эх үүсвэр, шалтгааныг зөв тогтоож, бохирдуулах эх үүсвэрийн нөлөөллийг хувь хэмжээгээр нарийн тооцож гаргах боломжтой. Ийм туршилтыг 1982 -1983 оны өвөл ЗХУ-ын (Хуучин нэрээр) мэргэжилтнүүдтэй хамтран улсын хэмжээнд хийж байжээ.

Байгаль орчны төв лаборатори, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн зэрэг байгууллагууд агаар бохирдуулагч үндсэн элемент болох хүхэрлэг хий ( $SO_2$ ), азотын давхар исэл ( $NO_2$ ) угаарын хий (CO) зэрэг хийн байдалтай бохирдуулагчийн хэмжээг тодорхойлох судалгааны ажил тодорхой хэмжээнд хийж байжээ.

Гэвч агаар бохирдуулагч нэг гол элемент болох тоосыг фракцаар нь ялгаж тодорхойлох, тэдгээр фракцууд дахь элементүүдийн агуулгыг тодорхойлох, агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийн агаарын бохирдолд оруулж буй хувь хэмжээг тогтоох, агаар дахь нүүрстөрөгчийн (Black Carbon) агууламжийг тодорхойлох зэрэг нэн шаардлагатай судалгаа, шинжилгээний ажил дутагдалтай байна.

Шинжлэх ухаан, технологийн сангаас авсан мэдээллээс үзвэл дээрх чиглэлээр сүүлийн 3 жилд судалгаа хийгдээгүй байна.

Агаарын чанарын хяналт шинжилгээ хөрөнгө мөнгө, багаж, тоног төхөөрөмжийн дутагдлаас шалтгаалж, шаардлагын хэмжээнд хийгдэхгүй байна.

Харин МУИС-ийн Цөмийн судалгааны төв Олон улсын атомын энергийн агентлаг болон Ази, номхон далайн бүсийн хэлэлцээрийн байгууллагуудаас хэрэгжүүлж буй “Азийн хотуудын агаарын бохирдол ба чанарын удирдлага RAS7/013” хэмээх хамтарсан судалгааны төслийг бүсийн хэмжээнд хэрэгжүүлж эхэлжээ.

Цөмийн судалгааны төвийн эрдэмтэд дээрх төслийн хүрээнд Улаанбаатар хотын агаар дахь тоосонцорын агууламжийг  $PM_{10}$  – 2.5,  $PM_{2.5}$  – 0 гэсэн 2 фракцаар тодорхойлж, түүнийг бий болгож буй эх үүсвэрүүдийн агаарын бохирдолд оруулах хувь хэмжээг нарийвчлан тогтоох судалгааг 2004 оны 10 дугаар сараас төслийн шугамаар ирсэн орчин үеийн техник, технологид үндэслэн хийж байна.

Энэ төслийг хэрэгжүүлснээр агаарын чанарыг зөв үнэлэхэд чухал ач холбогдолтой мэдээллийн бааз бий болох юм.

Агаарын чанарын талаархи мэдээллийг боловсруулах, хэрэглэгчдэд хүргэх үйл ажиллагаа холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдэж байгаа боловч энэ талын мэдээлэл хэрэглэгчдийн шаардлагыг төдийлөн хангаж чадахгүй байна. Тухайлбал агаарын чанарын талаархи мэдээлэл ард иргэдэд хүрэхгүй байна.

Засгийн газрын болон нийслэлийн төр, захиргааны зарим байгууллагын захиалгаар агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр судалгааны ажлууд хийдэг боловч тэр нь тохиолдлын чанартай, судалгааны ажлын дүнд үндэслэн зохих арга хэмжээ авдаггүй, нэг ижил төрлийн судалгааг өөр өөр байгууллагууд давхардуулан хийдэг зэргээс үзэхэд судалгаа шинжилгээний нэгдсэн бодлого алга байна.

Агаарын чанарыг зөв тодорхойлох, хянах, шинжлэх, мэдээлэх ажил шаардлагын хэмжээнд хийгдэхгүй байгаа нь агаарын бохирдлыг бууруулах талаар төрөөс баримтлах оновчтой, үр дүнтэй бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Агаар хамгаалахад чиглэгдсэн төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үр нөлөө

Байгаль орчны яам Агаарын тухай хуулийн 3.1.1 дэх заалтын дагуу Агаарыг хамгаалах хөтөлбөрийг 1999 онд Засгийн газраар батлуулан, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Энэ хөтөлбөрт дараахь үндсэн зорилтыг тусгажээ. Үүнд:

- Агаарыг хамгаалах үйл ажиллагааг зохицуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, менежментийн зохистой тогтолцоог бий болгох
- Агаарын чанарын хяналт шинжилгээний ажлын техник хэрэгсэл, боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх
- Агаарыг хамгаалах арга хэмжээний нийгэм, эдийн засгийн үндсийг бүрдүүлэх

Аудитаар Байгаль орчны яам дээрх хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хэрхэн зохион байгуулж, ямар үр дүнд хүрч байгааг тодорхойлохыг зорилоо.

Агаарыг хамгаалах хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 10 дэд зорилт, 19 арга хэмжээг тусгажээ.

Байгаль орчны яам хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг жил бүр гаргаж байсан гэх боловч албан ёсны баримт, тайланг тогтоосон хугацаанд гаргаж өгөөгүй байна.

Түүнчлэн хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарч буй үр дүнг төлөвлөсөн хэмжээтэй харьцуулж, үнэлэлт өгөх ажил хангалтгүй хийгджээ.

Тухайлбал “Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарч буй үр дүнг төлөвлөсөн хэмжээтэй зэрэгцүүлж, үнэлэлт өгсөн үү? Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийг ямар бүрэлдэхүүнтэйгээр, хэдэн удаа хэлэлцэж байсан бэ? Энэ талаар холбогдох шийдвэр, тушаал гарч байсан уу?” гэсэн асуултад тус яамны холбогдох албан тушаалтнууд эрх зүйн орчин бүрдээгүй, хөрөнгө санхүүгийн боломжгүй гэсэн тайлбар гаргаж, тодорхой хариу өгөөгүй юм.

Хөтөлбөрийн 5 дугаар зүйлд “Хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх үндэсний зөвлөл”-ийг байгуулж ажиллахаар заажээ. Гэвч энэхүү үндэсний зөвлөлийг өнөө хүртэл албан ёсоор байгуулаагүй байна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө нөөцийг тооцоолж, эх үүсвэрийг шийдвэрлэх талаар тодорхой арга хэмжээ авч байгаагүйн зэрэгцээ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгө байгаа эсэх нь мэдэгдэхгүй, энэ талаар тооцоо судалгаа алга байна.

Агаарын чанарын хяналт шинжилгээ хийх цөөн тооны төрийн албан хаагчдын цалин, үйл ажиллагааны зардлыг эс тооцвол улсын болон нийслэлийн төсөвт хөтөлбөр хэрэгжүүлэх зардал тусгагдаагүй байна.

Агаарын чанарын албаны үүргийг одоогийн байдлаар Ус цаг уур, орчны шинжилгээний газрын байгаль орчны асуудал хариуцсан нэг мэргэжилтэн хавсран гүйцэтгэж байна.

Хөтөлбөрийн 4 дүгээр зүйлийн 3-т утаагүй түлш болон бүрэн шаталттай шинэ хийцийн зуух үйлдвэрлэх, мэргэжлийн боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх арга хэмжээ төлөвлөжээ.

Тухайлбал, нийслэлийн гэр хорооллыг стандартын шаардлага хангасан зуухаар 2005 онд бүрэн, нийслэл болон зарим аймгийн төвийн гэр хорооллын өрхийн 50 хувийг 2010 онд утаагүй түлшээр хангах зорилт тавьсан ч хэрэгжсэнгүй.

Энэ зорилтын хүрээнд 2001 оны 3 дугаар сараас Даян дэлхийн байгаль орчны сан, Дэлхийн банкны тусламжаар хот суурин газарт шинэ сайжруулсан зуухны хэрэглээг өргөжүүлэх “Гэрийн зуух” төслийг 2001-2005 онд хэрэгжүүлэхээр болжээ. Энэ төслийн хүрээнд гэрийн зуухны шинэ загварууд, “Хатуу түлшээр ажилладаг гэрийн зуух. Техникийн ерөнхий шаардлага” MNS 5216:2002 гэсэн стандарт, ханын пийшин өрөх жижиг бизнес эрхлэгчдийн сургалт, ердийн зуухны сайжруулалт хийх техникийн ажилтны сургалт зохион байгуулах, үйлдвэрлэгчдийг дэмжих зэрэг үйл ажиллагаа явуулсан хэдий ч үр дүн муутай байна. Энэ нь түүхий эдийн олдоц ховор, үйлдвэрлэл нь улирлын чанартай, өртөг өндөр, үйлдвэрлэл борлуулалтын судалгааг цогц байдлаар хийгээгүй зэргээс шалтгаалсан байна.

Энэ бүхнээс үзэхэд Засгийн газрын хөтөлбөрийн хэрэгжилтийг оновчтой удирдаж, зохион байгуулаагүй, хөтөлбөрийн үр дүнг үнэлж, холбогдох арга хэмжээ авч байгаагүй гэж хэлж болохоор байна.

Энэ нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаар нэгдсэн бодлого байхгүй, дээрх асуудлуудыг хариуцсан байгууллага, албан тушаалтнууд хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүйтэй холбоотой бөгөөд улам бүр нэмэгдэж байгаа агаарын бохирдлыг бууруулах талаар төрөөс дорвитой арга хэмжээ авч, үр дүнд хүрэхгүй байгаагийн илрэл юм.

2002-2003 онд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Орчны бохирдлыг бууруулах чиглэлээр дараахь хөтөлбөд баталжээ.

- Нийслэлийн экологийн хөтөлбөр
- Эрүүл хот хөтөлбөр
- Улаанбаатар хотын агаар, ус, хөрсний бохирдлыг багасгах хөтөлбөр

Эдгээр хөтөлбөрөөс бид зөвхөн агаарын бохирдлыг багасгахад чиглэгдсэн зорилт, арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг авч үзэхэд бүрэн хэрэгжээгүй буюу эсвэл бодит үр дүнд хүрээгүй байна.

Тухайлбал, Улаанбаатар хотод бүртгэлтэй авто тээврийн хэрэгслүүдийг “Эко тэмдэгжүүлэх”, хотын агаарын чанарыг тодорхойлох, хяналт шинжилгээ хийх мэргэжлийн лаборатор байгуулах, гэр хорооллын айл өрхийг сайжруулсан зуухаар хангах зэрэг ажил бүрэн хэрэгжээгүй байна.

Нийслэлийн төр, захиргааны холбогдох байгууллагууд дээрх хөтөлбөрийн хэрэгжилтийг хангалтгүй зохион байгуулжээ.

Агаарын талаархи хууль тогтоомжийг Засгийн газрын болон нийслэлийн төр, захиргааны байгууллагууд мөрдөж буй байдал

Хийн мандлын агаарыг хамгаалах, түүнийг зохистой ашиглахтай холбогдсон харилцааг Агаарын тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан бусад хууль, эрхийн актаар зохицуулж байна.

Агаарын тухай хуулийн 3 дугаар зүйлд байгаль орчны болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын агаарыг хамгаалах талаар хүлээх дор дурдсан чиг үүргийг тодорхойлсны хамт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын агаарт гаргаж буй бохирдуулах бодис, физикийн хортой нөлөөллийн байдалд тавих хяналтыг мэргэжлийн хяналтын байгууллага болон байгаль орчны улсын байцаагч хэрэгжүүлэхээр заажээ:

Байгаль орчны яам:

- Агаарыг хамгаалах хөтөлбөр боловсруулан Засгийн газраар батлуулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах
- Агаарын чанарын хяналт шинжилгээний ажлыг зохион байгуулах
- Агаарыг хамгаалахтай холбогдсон дүрэм, журам батлах, стандартын төсөл боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулах

Эрүүл мэндийн яам

- Агаар бохирдуулах бодисын хүлцэх агууламж, агаарт үзүүлэх физикийн хортой нөлөөллийн түвшний стандартын төслийг боловсруулж, эрх бүхий байгууллагаар батлуулах
- Агаарын бохирдол, физикийн хортой нөлөөлөл хүний эрүүл

## мэндэд нөлөөлөх байдалд хяналт тавих

Агаарыг хамгаалахад чиглэгдсэн хууль, эрхийн актуудыг өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулж боловсронгуй болгох ажил бараг хийгдээгүй, тэдгээрийн хоорондын уялдаа муу, төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагуудын үүрэг чиглэл тодорхой биш, агаарыг хамгаалах нэгдсэн бодлого алга байна.

Агаарыг хамгаалах ажлын удирдлага, чанарын хяналт, мэдээллийн талаархи хөтөлбөр, дүрэм, журам, заавруудын дийлэнх нь 1996 - 2001 онд батлагдсан бөгөөд өнөөгийн нөхцөл, шаардлагад нийцэхгүй байна.

Аудитад хамрагдсан байгууллагууд “Агаарыг хамгаалах, түүнийг зохистой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах хууль, эрх зүйн орчин өнөөгийн шаардлагад нийцэж байна уу?” гэсэн асуултад 100 хувь нийцэхгүй байгаа гэсэн хариулт өгсөн байна. Гэвч “Түүнийг боловсронгуй болгох ямар арга зам байна вэ?” гэсэн асуултад нэг ч байгууллага тодорхой санал ирүүлээгүй байна.

Агаарыг хамгаалах хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд Эрүүл мэндийн яамны зүгээс авч хэрэгжүүлэх нэг ч арга хэмжээ төлөвлөгдөөгүй байна.

2005 оны 12 дугаар сард хүний эрүүл мэндэд орчны нөлөөлөл хэрхэн нөлөөлж байгаад хийсэн судалгаануудад үндэслэн “Орчны эрүүл мэнд Үндэсний хөтөлбөр”-ийг Засгийн газраар батлуулжээ.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэл зэрэг баримт бичгүүдэд дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгажээ.

## Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2000–2004 он)

- Байгалийн нөөц баялаг ашигласны болон байгаль орчныг бохирдуулсны төлбөр, хураамжийг шинэчлэн тогтоож байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, санхүүгийн тогтвортой эх үүсвэрийг бий болгоно.
- Байгаль орчны хяналтын тогтолцоог боловсронгуй болгож ажлын үр дүнг сайжруулна. Ус, цаг уур, орчны болон бохирдол, цацрагийн хяналт шинжилгээний тогтолцоо, техник, технологийг шинэчлэнэ.
- Улаанбаатар хотын орчны бохирдлыг бууруулах зорилгоор айл өрхийг бүрэн шаталттай, түлш бага хэрэглэдэг зуухаар дэс дараатай хангах ажлыг зохион байгуулна.
- Байгаль орчны 2 талын болон олон талын хамтын ажиллагааг өргөжүүлнэ. Экологийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд гадаад орон, олон улсын байгууллагын тусламж дэмжлэгийг нэмэгдүүлэх

арга хэмжээ авна.

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр (2004-2008 он)

- Хөрс, ус, агаар зэрэг хүрээлэн буй орчныг бохирдуулсны хариуцлагын эрх зүйн тогтолцоог бүрдүүлж, байгаль орчинд хоргүй, утаа багатай хатуу, шингэн, хийн түлшний хэрэгцээг өргөтгөхөд чиглэгдсэн санаачилгыг дэмжинэ.
- Хүрээлэн буй орчны төлөв байдлын тухай мэдээллийг орон нутгийн статистикийн мэдээлэлд оруулж хэвшүүлнэ.
- Байгаль орчинг бохирдуулсны торгуулийг байгаль бохирдуулагчийн шууд эх үүсвэртэй холбон гаргуулах тогтолцоог нэвтрүүлнэ.
- Байгаль орчны мэдээллийн санг төрөлжүүлэн баяжуулж, байгалийн нөөцийн мониторинг хийх ажилд орчин үеийн техник, мэдээллийн технологийг нэвтрүүлэх ажлыг дэмжинэ.
- Хот суурин газрын орчинг ойжуулах, цэцэрлэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ.

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэл

- Хөрс, ус, агаар зэрэг хүрээлэн буй орчныг бохирдуулсны хариуцлагын эрх зүйн тогтолцоог бүрдүүлж, байгаль орчинд хоргүй, утаа багатай хатуу, шингэн, хийн түлшний хэрэглээг өртгөтгөхөд чиглэсэн аж ахуйн үйл ажиллагааг дэмжиж нүүрсээр шахмал түлш хийх үйлдвэр байгуулах зэргээр Улаанбаатар хотын утааны асуудлыг орон нутагтай хамтран шийдвэрлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
- Ус, хөрс, агаарын бохирдлын байдлын тухай статистик мэдээллийг ил тод болгоно.
- Байгаль орчны мэдээллийн санг төрөлжүүлэн баяжуулж, байгалийн нөөцийн мониторинг хийх ажилд орчин үеийн техник, мэдээллийн технологийг нэвтрүүлэх ажлыг дэмжинэ.

Аудитын явцад холбогдох байгууллагаас авсан асуулга, судалгаа, мэргэжлийн хүмүүстэй хийсэн ярилцлагаас дүгнэхэд агаарыг хамгаалах талаар төрөөс баримтлах бодлогыг оновчтой тодорхойлоогүй гэж үзэж байна.

Тухайлбал, оролцогч талуудын уялдаа холбоо тодорхой биш, тохиолдлын чанартай хэт жижиг асуудлыг тусгасан, холбогдох талуудын хамтын ажиллагаа, салбар дундын нэгдсэн бодлого үгүйлэгдэж байна.

Зах зээлийн зарчмаар агаар бохирдуулагч нь агаар бохирдуулсны төлөө

хариуцлага хүлээдэг, төлбөр төлдөг эрх зүйн үндсийг бүрдүүлж чадаагүй байна.

Уг нь Агаарын тухай хуулийн 19 дүгээр зүйлд “Агаарт бохирдуулах бодис гаргадаг, физикийн хортой нөлөө үзүүлдэг болон агаарыг савлах, бусад аргаар үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага төлбөр төлнө. Төлбөрийн хэмжээ, түүнийг төлөх журмыг хуулиар тогтооно” гэж заажээ.

Байгаль орчны яам Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн төслийг 1996 оноос хойш холбогдох байгууллагуудад удаа дараа оруулж байсан боловч гэр хорооллын айл өрхөөс агаар бохирдуулсны төлбөр авах оновчтой хэлбэрийг сонгож чадаагүй, бусад салбарын саналыг нэгтгэж зөвшилцөөгүй зэрэг шалтгаанаас батлагдаагүй өдий хүрчээ.

Хэрэв энэ хууль батлагдаж хэрэгжсэн бол агаарын бохирдлыг бууруулахад чиглэгдсэн арга хэмжээг санхүүжүүлэх хөрөнгө мөнгөний асуудлыг шийдвэрлэхэд тус дөхөм болох байжээ.

Агаарын чанарын хяналт шинжилгээний ажлыг сайжруулах, түүний бүтэц, тогтолцоо, удирдлага, зохион байгуулалтыг улам боловсронгуй болгох, нэгэнт хуулиар бий болсон бүтэц, тогтолцоог жинхэнэ утгаар нь бүрэн хэрэгжүүлэх ажил хангалтгүй байна.

Тухайлбал, Агаарын тухай хуулийн 4.3-т зааснаар Агаарын чанарын асуудал эрхэлсэн мэргэжлийн албаны орон нутаг дахь салбарыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан дүрмийн дагуу Засаг даргын удирдлага дор ажиллуулах ёстой.

Гэтэл агаарын бохирдолд хамгийн ихээр нэрвэгдэж буй Улаанбаатар хотод Агаарын чанарын алба өнөөг хүртэл байгуулагдаагүй байна. Энэ талаар Байгаль орчны яам болон Ус цаг уур, орчны шинжилгээний газраас нийслэлийн удирдлагад хэд хэдэн удаа хандаж байжээ.

Ийнхүү байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагууд хамтран ажиллаж чадахгүй байгаагаас агаарыг хамгаалах, түүнийг зохистой ашиглах талаар ахиц дэвшил гарахгүй байна.

Бусад оронд агаарын бохирдлын асуудал хэдийгээр тулгарч байгаа боловч оновчтой зөв бодлого, зохион байгуулалт, хөрөнгө нөөцийг зөв хуваарилсны үндсэн дээр агаарын бохирдлыг бууруулж чаджээ.

Тухайлбал, Английн Үндэсний аудитын газраас 2001 онд агаарын чанарыг сайжруулах бодлогын хэрэгжилтэд хийсэн байгаль орчны аудитын дүгнэлтэд холбогдох байгууллагууд энэ талын бодлогыг оновчтой боловсруулж, үр дүнтэй хэрэгжүүлж байгаа талаар дурджээ.

Агаарын чанарыг сайжруулах талаар оновчтой бодлого боловсруулж,

хэрэгжүүлж байгаа гол хүчин зүйл нь орц буюу бодлого боловсруулах үйл явцад мэдээлэл, зөвлөгөө өгөх үүрэг бүхий холбогдох талууд болон бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгч талуудын хоорондын харилцаа, үүрэг хариуцлагыг нарийвчлан тодорхойлж өгсөн явдал юм.

Улсын Их Хурлын болон хууль, хяналтын зарим байгууллагууд орчны бохирдлыг бууруулахтай холбогдсон хууль, тогтоомжийн биелэлтийг шалгаж, үнэлэлт дүгнэлт, зохих шийдвэрүүд гаргадаг боловч түүнийг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтнууд холбогдох арга хэмжээ авч ажиллахгүй байгаагаас тодорхой үр дүнд хүрдэггүй байна.

Тухайлбал, Улсын Их Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн Байнгын хорооноос томилогдсон ажлын хэсгийн гишүүд 2003 оны 5 дугаар сард Орчны бохирдлыг бууруулахтай холбогдсон хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг Нийслэлийн нутаг дэвсгэрт шалгаж, дүгнэлт санал боловсруулан “Хуулийн хэрэгжилтийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн Байнгын хорооны тогтоол гаргажээ.

Дээрх шийдвэрийн дагуу Монгол Улсын Засгийн газар болон Нийслэлийн Засаг даргад орчны бохирдлыг бууруулах чиглэлээр дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг даалгасан боловч үр дүнд хүрээгүй байна:

- Улаанбаатар хотын цахилгаан станцууд орчиндоо үзүүлэх нөлөөллийг багасгах, утаа багатай түлш, шингэрүүлсэн шатдаг хийг ахуйн хэрэгцээнд ашиглах, гэрийн болон бага оврын уурын зуухыг шинэчлэх хүрээнд нэгэнт эхэлсэн ажлыг үр дүнд хүргэх, ялангуяа үйлдвэрлэгдээд борлогдоогүй байгаа 10 мянган зуухны үнийг хямдруулах арга замыг олж, энэ онд багтаан борлуулах арга хэмжээ авах, цаашид тэдгээр техник, технологийг шинэчлэх хөрөнгийн эх үүсвэрийг олж, ашиглах арга хэмжээ авах
- Хотын агаарын бохирдлыг бууруулах, авто тээврийн хэрэгслийн түлшний зарцуулалтыг хэмнэх зорилгоор нийтийн тээврийн хэрэгслийн түлшийг шатдаг шингэн хийгээр орлуулах болон шаардлагатай нэмэлт техник, төхөөрөмжөөр шинэчлэн тоноглох арга ажиллагааг туршин нэвтрүүлэх

Засгийн газрын болон Нийслэлийн төр захиргааны байгууллагууд шалгалтын мөрөөр тодорхой арга хэмжээ авч үр дүнд хүрээгүй, агаарыг хамгаалахад чиглэгдсэн хууль, тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаа нь Улаанбаатар хотын агаарын бохирдлын түвшин буурахгүй байгаагийн нэг шалтгаан болж байна.



Агаарын бохирдлыг багасгахад зориулсан төсөв хөрөнгийн хүрэлцээ, зарцуулалт

Аудитад хамрагдсан байгууллагаас сүүлийн 3 жилд агаарын бохирдлыг бууруулахад зарцуулсан хөрөнгийн судалгааг хавсралт №2-д үзүүлэв.

Аудитад хамрагдсан сайд нарын багцад сүүлийн 3 жилд агаарын бохирдлыг бууруулахад зориулсан хөрөнгө батлагдаагүй байна.

Байгаль орчны сайдын 2003 оны 235 дугаар тушаалаар Байгаль хамгаалах сангаас “Улаанбаатар хотын агаарын бохирдлын өнөөгийн түвшин, түүний хүчин зүйлсийн судалгаа, үнэлэлт” судалгааны ажилд 20.0 сая, “Гал түргэн ноцоогч түлшийг туршиж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх” төсөлд 30.0 сая төгрөг тус тус зарцуулахаар шийдвэрлэжээ.

Дээрх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг тендер зарлаж шалгаруулалгүй “ТЕКОЛ” ХХК, “Зэлэм” ХХК-уудтай шууд гэрээ байгуулжээ.

“ТЕКОЛ” ХХК судалгааны ажилд зориулан олгосон 20.0 сая төгрөгөөс 11.0 сая төгрөгийн үнэтэй “Diesel smoke tester”, 10.1 сая төгрөгийн үнэтэй “Automotive Emission Analyser” гэдэг автомашины утаа хэмжих багаж худалдан авсан гэх боловч анхан шатны баримт материал бүрдүүлээгүй байна.

Дээрх 2 багажийг Байгаль орчны төв лабораторид албан ёсны акт баримтгүй хүлээлгэж өгсөн боловч түүнийг нь данс бүртгэлд тусгаж аваагүй байна.

Байгаль орчны яам дээрх төсөл, судалгааг ямар зорилгоор хийлгэсэн нь тодорхойгүй, судалгааны дүнг үнэлж дүгнээгүй, ашиглаагүй, хөрөнгийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэхүү судалгааны ажлын дүнг мэргэжлийн байгууллагаар үнэлүүлээгүйн гадна судалгааны ажлын 72 хуудас (36 хуудас нь хууль, эрхийн актын заалтуудыг хуулж бичсэн) тайланд дурдагдсан тоо, өгөгдлүүд нь Байгаль орчны төв лабораторийн мэдээ, тайланд үндэслэгджээ.

Байгаль орчны яам энэ судалгааны ажлын дүнг үндэслэж ямар нэгэн арга хэмжээ авч, тодорхой шийдвэр гаргаагүй байна.

Байгаль орчны төв лабораторид өгсөн автомашины утаа хэмжих багаж уг лабораторид өмнө нь байсан учир огт ашиглаагүй байна.

Харин гал түргэн ноцоогч түлшийг туршиж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажилд зориулж олгосон 30.0 сая төгрөгөөр үйлдвэрлэлд шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авч, гал түргэн ноцоогчийг төрөл бүрээр туршиж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх шатандаа орсон байна.

**Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, баримт материал, хийсэн судалгаа, дүн шинжилгээнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна.**

1. Агаарын чанарыг үнэлэх, хянах, шинжлэх, мэдээлэх ажил хангалтгүй байна.

1.1 Хүрээлэн буй орчны агаарт байгаа хүн амын эрүүл мэнд болон хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлдөг бохирдуулагчийг хөрөнгө мөнгө, тоног төхөөрөмжийн дутагдалтай байдлаас болж хангалттай түвшинд бүрэн хянаж шинжилж чадахгүй байна.

1.2 Агаарын бохирдлыг бууруулахад чиглэгдсэн нэгдсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд судалгааны ажлын дүнг ашиглаж, тодорхой арга хэмжээ аваагүй байна.

2. Агаарыг хамгаалахад чиглэгдсэн төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт хангалтгүй байна.

2.1 Агаарыг хамгаалахад чиглэгдсэн төсөл, хөтөлбөрүүдийг боловсруулахдаа хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө нөөц, хүрэх үр дүнг тодорхой тусгаагүй байна.

2.2 Холбогдох байгууллага, албан тушаалтнууд хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүйгээс хөтөлбөрүүд бүрэн хэрэгжээгүй байна.

3. Төрийн захиргааны байгууллагууд хуулиар хүлээсэн агаарыг хамгаалах үүргээ хангалтгүй биелүүлж байна.

3.1 Агаарын тухай хуульд нийцүүлэн гаргасан дүрэм, журам, заавар, хөтөлбөрт төрийн захиргааны болон орон нутгийн байгууллагуудын үүрэг чиглэл, ажлын уялдаа холбоог тодорхой тусгаагүйн гадна холбогдох байгууллагууд агаарыг хамгаалах, бохирдлыг бууруулахад чиглэгдсэн хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох нэгдсэн бодлого боловсруулж, зохион байгуулахгүй байгаагаас энэ ажил удаашралтай байна.

3.2 Агаарыг хамгаалахад чиглэгдсэн хууль, эрхийн актууд өнөөгийн нөхцөл, шаардлагад нийцэхгүй байна.


3.3 Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын агаарт гаргаж буй бохирдуулах бодис, физикийн хортой нөлөөллийн байдалд тавьж буй хяналт шалгалтын мөрөөр тодорхой ажил зохион байгуулаагүй байна.

4. Агаарын бохирдлыг бууруулахад зориулсан төсөв хөрөнгийн хүрэлцээ муу, зарцуулалтын үр ашиг хангалтгүй байна.

4.1 Төсөл, хөтөлбөрүүдийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.

4.2 Төсөл, арга хэмжээний хөрөнгө нөөц, эцсийн үр дүнг тооцолгүй үр ашиг муутай хөрөнгө оруулалт хийж байна.

Байгаль  
орчны  
ямны  
санал



**МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД**

210620а Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Бага тойруу 44, Засгийн газрын III байр,  
Утас: 32-65-95, Факс: 32-14-01,  
E-mail: monenv@mail.mn

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ

2006-02-06 № 2/231  
танай 2005-01-23-ны № 1/30-т


“Төрийн аудитын тухай” Монгол Улсын хуулийн дагуу Засгийн газар болон Нийслэлийн төрийн захиргааны байгууллагууд хотын агаарын чанарыг хэрхэн үнэлж, шийдвэрлэж буй байдалд хийсэн аудитын тайлантай танилцлаа.


Аудитын үндсэн дүгнэлт, зөвлөмжийг дэмжиж байна. Улаанбаатар хот болон суурин газрын агаар хамгаалах, чанарыг тодорхойлоход нэн шаардлагатай эдийн засаг, эрх зүйн орчин сул зэрэг нь өргөн цар хүрээтэй, шийдвэртэй арга хэмжээг өнөө хүртэл авч хэрэгжүүлээгүй үндсэн шалтгаан болж байна.

Байгаль орчны яам 2005, 2006 оны төсвийг хэлэлцэх үед Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх асуудлыг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлж байсан болно. Мөн агаар бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулан хэлэлцүүлсэн боловч дэмжлэг авч чадаагүй юм.

Агаар хамгаалах хөтөлбөрийг улсын төсөв, Монгол Улсын хотжилтын бодлоготой нягт уялдуулан тодорхой үйл ажиллагааны баримт бичиг болгон шинэчлэх, орчныг бохирдуулсан болон байгальд хохирол учруулсныг зохицуулах “Экологийн хохирлыг барагдуулах тухай” Монгол Улсын хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.

“Агаарын тухай” Монгол Улсын хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь нутгийн захиргааны байгууллагуудад тодорхой дэмжлэг туслалцааг үзүүлж, холбогдох шаардлагыг тавин ажиллах болно.






И.ЭРДЭНЭБААТАР

0800032

Нийслэлийн  
засаг  
даргын  
санал

  
**МОНГОЛ УЛС**  
**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА**  
210646 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сүхбаатарын талбай 11, Утас/Факс: 32-71-99

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОР Л.ЖАВЗМАА ТАНАА

2006.02.03 № 1/194  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т


Санал хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 19.3.1 –д заасны дагуу Нийслэлийн агаарын бохирдлыг багасгах талаар холбогдох байгууллагуудаас хэрэгжүүлж буй арга хэмжээ, тэдгээрийн үр нөлөөнд хийсэн аудитын тайлангийн төслийг анхааралтай уншиж танилцлаа.

Танай байгууллагаас хийсэн уг тайланд тусгагдсан дүгнэлт, зөвлөмжтэй санал нэг байна. Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэсэн нийслэлийн хэмжээнд авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллах болно.

Агаарыг хамгаалахад зарцуулагдсан хөрөнгийн судалгаа гэдэг дээр 7 болон 13 –д байгаа төслүүд давхарсан болохыг анхаарна уу.

Хүндэтгэсэн,

  
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц. БАТБАЯР

0200105  
(My.doc.toof.Bat)

**Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дараахь албан тушаалтанд зөвлөж байна.**

1. Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатарт

- Хүрээлэн буй орчны агаарын төлөв байдлыг судлах, хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангах, хяналт шинжилгээний цэг, сүлжээг оновчтой зохион байгуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
- Агаарын чанарыг тодорхойлох ажлыг хэвийн явуулахад шаардагдах хөрөнгө, тоног төхөөрөмжийн судалгааг мэргэжлийн байгууллагатай хамтран гаргаж, хөрөнгийн эх үүсвэрийг судалж, шийдвэрлүүлэх.
- Агаарын чанар, агаар бохирдуулагч эх үүсвэрүүдээс агаарт гаргаж буй хорт бодисын үр дагавар, түүнээс сэргийлэх арга хэмжээний талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тогтмол мэдээлж байх.
- Агаарыг хамгаалах хөтөлбөрийг холбогдох байгууллагуудтай хамтран өнөөгийн нөхцөл, шаардлагад нийцүүлэн шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх.
- Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хууль батлуулах болон холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх.
- Агаар бохирдуулсны төлөө хүлээх хариуцлагын тогтолцоо, түүний эрх зүйн үндэс, хэрэгжих механизмыг бүрдүүлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах.
- Агаарын бохирдлыг багасгах бодлого боловсруулах /2006-2010/

2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч  
Ц.Батбаярт

- Агаарын чанарын албыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу байгуулж ажиллуулах
- Улаанбаатар хотод бүртгэлтэй автомашинуудыг ЭКО тэмдэгжүүлэх арга хэмжээ авах
- Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тоог нэмэгдүүлэхгүй байх, улмаар бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- Нам даралтын уурын зуух ашиглаж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн барилга, байгууламжийг төвлөрсөн халаалтын шугамд холбох ажлыг судалж шийдвэрлэх
- Шахмал түлшийг хэрэглэх шаардлагыг олон нийтэд сурталчлаж хэрэглэх

3. Түлш, эрчим хүчний сайд Б.Эрдэнэбат, Зам, тээвэр, аялал жуулчлалын сайд Ц.Цэнгэл, Эрүүл мэндийн сайд Л.Гүндалай, Барилга, хот байгуулалтын сайд Ж.Наранцацралт нарт

- Нийслэлийн агаарын бохирдлын түвшинг бууруулах чиглэлээр Байгаль орчны яам, болон нийслэлийн төр захиргааны холбогдох байгууллагуудтай хамтран ажиллан үр дүн гаргах.

Аудитын тайлантай холбоотой нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.ГАНБИЛЭГ

## Агаарын үндсэн бохирдуулагчдын тухай товч тайлбар

Бохирдуулах бодис	Эх үүсвэр	Хор нөлөө
Нүүрстөрөгчийн исэл (СО)	Ойн түймэр, чулуужсан түлшний дутуу шаталт (бүх утаа ялгаруулалтын 3-ны 2 орчим), болон машин, пийшин /зуух/ тамхины утаан дахь органик бодисууд. Хот суурин газрын угаарын хийн бохирдлын 60 илүү %-г автомашин ялгаруулна. Хвйтэнд шаталт харьцангуй бүрэн бус явагдахаас гадна бохирдуулагчийг газрын гадарга орчимд тогтоон барьж байдаг инверси ихээхэн тохиолддогос хвйтний улиралд угаарын хийн бохирдол их байна	Нүүрстөрөгчийн дутуу исэл уушигаар дамжин цусны урсгалд орж, эсэнд хвчилтерөгч зөөвөрлөгч гемоглобинд нэгдэнэ. Ингэснээр хвний эд эрхтэнд хврэх хвчилтерөгчийн хэмжээг багасгаж дараахь сөрөг нөлөөллийг үзүүлнэ. <ul style="list-style-type: none"> <li>Ангина, зврх судасны өчинтэй хвмвс гол эрсдэлтэй бүлэгт багтана. Ийм хвмвсийн цээж давчдаж, зврх судасны евчний бусад шинж тэмдэг илэрнэ.</li> <li>Угаарын хий их вед эрүүл хвмвсийн ч ухаан санаа сааталд орж, харах чадвар буурч болно.</li> </ul>
Хүхрийн исэл (SO <sub>x</sub> )	Нүүрс болон тосны агууламжтай хүхрийг айл өрх, аж үйлдвэр, эрчим хүчний үйлдвэрт шатаах, хүдэр, галт уулын лавын хольцтой хүхэр хайлах	Хвхдүүд, багтраа өвчтэй насанд хврэгчид хвхэрлэг хийн нөлөөнд өртөмтгий. Маш их агууламжтай вед эрүүл хвмвсийн ч толгой эргэж, цээж давчдан амьсгаадна. Хвхэрлэг хий, тоосонцор хоёулаа хавсарч ихээр илрэх вед амьсгалын замын өвчний шалтгаан болж, уушигны хамгаалах механизм алдагдаж, зврх судасны архаг евчнийг хурцатгана.
Азотын исэл (NO and NO <sub>2</sub> )	Моторт тээврийн хэрэгсэл, тийрэлтэт онгоцонд өндөр температурт түлш түлэх, чулуужсан түлш түлдэг аж үйлдвэр, эрчим хүчний үйлдвэр, аянга цахилгаан	Маш их хортой, амьсгалын замын эд эрхтнүүдийг гэмтээдэг хий юм. Энэ хий уушгинд нэвтрэн орж салст бүрхэвчинд наалдах азотлог хвчлийг үүсгэнэ. Мөн гуурсан хоолойн багтраа, амьсгалын замын архаг өвчлөлийг нэмэгдүүлдэг.
Тоосонцор PM агаарт тархсан хөдөлгөөнгүй макро бохирдуулагч	Ойн түймэр, салхины элэгдэл, нүүрс түлэх, уурхай, барилгын ажил, автомашины үүсгэх тоосжилт, автомашины утаа, нүүрс түлдэг цахилгаан эрчим хүчний үйлдвэрүүд	10мкм-ээс бага диаметр бүхий тоосонцор амьсгалын замаар орж, амьсгалын системд хуримтлагддаг тул хвний эрүүл мэндэд хор нөлөөтэй.
Озон - O <sub>3</sub> Vнэргүй, өнгөгүй хий, хүчилтөрөгчийн 3 атомаас бүрэлдэнэ.	<b>Муу озон.</b> Агаар мандлын доод давхарга буюу газрын гадарга орчимд автомашин, цахилгаан станц, уурын зуух зэрэг эх үүсвэрээс ялгардаг бохирдуулах бодисууд дулаан, нарлаг едер урвалд орж озоныг үүсгэнэ.  Халуун, хурц нарлаг едрүүд үргэлжлэх зуны улиралд озоны бохирдол их байна.	Ихэнх цагаа гадаа өнгөрөөдөг хвхдүүд ба насанд хврэгчид, астма зэрэг амьсгалын эрхтний өвчтэй хвмвс, озонд онцгой мэдрэг хвмвст дараахь нөлөөллийг үзүүлнэ. <ul style="list-style-type: none"> <li>Амьсгалын системийг почироон ханиалгуулж, хоолой хорсон, цээж давчдуулна.</li> <li>Уушигны ажиллагааг сулруулж, гвн хвчтэй амьсгалахад хвндрэл учруулна. Амьсгал ердийнхээс илүү хурдан, өнгөцхөн болно. Уушигны ажиллагааны энэ сулрал тухайн хвний гадаа ажиллах боломжийг хязгаарлана.</li> <li>Багтрааг хурцатгана. Агаарт озон их байх вед багтраатай ихэнх хвмвсийн эмчид хандах нь ихэсдэг ба ввний нэг шалтгаан нь озон харшил үүсгэж, багтрааны голлох үүсгэгч болно.</li> </ul>



**Агаарыг хамгаалахад зарцуулсан  
хөрөнгийн судалгаа**

№	Хөтөлбөр, төсөл батлах шийдвэрийн нэр	Хөрөнгийн зарцуулалт (төсөл, арга хэмжээний нэр)	Дүн (сая.төг)		Хэрэгжүүлэгч байгууллага
			Батлагдсан	Гүйцэтгэл	
<b>Төсвийн хөрөнгөөр</b>			<b>2,912.6</b>	<b>205.8</b>	
1	НИТХТХ-ын 1998 оны 30 дугаар тогтоол	Улаанбаатар хотын экологийн хөтөлбөр 1998-2000 он	94.5		БОХГазар НЗДТГазар
2	НИТХТХ-ын 2002 оны 72 дугаар тогтоол	Эрүүл хот хөтөлбөр 2003-2004 он	848.5		НЗДТГ, БХХГазар
3	НИТХТХ-ын 2002 оны 160 дугаар тогтоол	Нийслэл Улаанбаатар хотын агаар, ус, хөрсний бохирдол багасгах хөтөлбөр 2003-2004 он	1,725.0		
4	БОС-ын 2003 оны 235 дугаар тушаал	"Гал түргэн ноцоогч" тоног төхөөрөмж худалдан авах	30.0	30.0	Зэлэм ХХК-д
5		Улаанбаатар хотын агаарын бохирдлын өнөөгийн түвшин, түүний хүчин зүйлсийн судалгаа	20.0	20.0	Тэкол ХХК
6	БОС-ын 2003 оны 218 дугаар тушаал	БОШТЛабораторид тоног төхөөрөмж худалдан авах тухай	90.0	90.0	УЦУОШГазар
7	Нийслэлийн төсвийн Урсгал зардал	Улаанбаатар хотын агаарын цахим загвар төслийн ажилд	40.0	40.0	Газар зүй, геологийн судалгааны төв
8	НЗД-ын 2003 оны 207 дугаар захирамж	ДЦСтанц, халаалтын зуухны яндангаар гарах утааны бохирдлыг багасгах	5.8	5.8	ШУТИС-ийн зуухны туршилт судалгааны төвд
9	НЗД-ын 2003 оны 400 дүгээр захирамж	Сурталчилгаанд зориулж	3.4	3.4	Зууны мэдээ сонины газарт
10		Гэрийн зуух төсөлд	0.8	0.8	
11		Утаагүй зуух хийхэд	5.0	5.0	Хараагүйчүүдийн үйлдвэрт
12		Хорт утаа хэмжих багаж авахад	10.8	10.8	Хотын тээврийн удирдах газарт
<b>Гадаад орны зээл, тусламжын хөрөнгөөр</b>			<b>60,000.0</b>	<b>44,940.8</b>	
13	АХБанкны хөнгөлөлттэй зээл 2004 он	ТЭЦ-3 4 зуух шинэчлэхэд	45,000.0	44,940.8	ТЭЦ-3
14	Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын буцалтгүй тусламж 2002-2004	Хүрээлэн буй орчны бохирдлын үнэлгээ	10,000.0		Эрүүл мэндийн яам
15		Гэрийн доторх агаарын бохирдол эрүүл мэндэд нөлөөлөх нь	5,000.0		Эрүүл мэндийн яам
<b>Аж ахуй нэгжийн өөрийн хөрөнгөөр</b>			<b>14,213.0</b>	<b>14,972.5</b>	

17	өөрийн хөрөнгөөр	хорт нэгдлийг багасгах нам даралтын температурын засварт	11,000.0	11,960.0	ТЭЦ-3
18	өөрийн хөрөнгөөр	Үнсэн сангийн усны системийн засварт	13.0	12.5	ТЭЦ-3
19	өөрийн хөрөнгөөр	Үнс хадгалах үнсэн сан байгуулах	3,000.0	2,800.0	ТЭЦ-4
20	өөрийн хөрөнгөөр	Газрын хөрсийг нөхөн сэргээх	200.0	200.0	ТЭЦ-4
		<b>Бүгд дүн</b>	<b>77,125.6</b>	<b>60,119.1</b>	

Байгаль орчны аудитын тайланг  
баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Нийслэлийн агаарын бохирдлыг багасгах талаар холбогдох байгууллагаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, тэдгээрийн үр нөлөөнд хийсэн байгаль орчны аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Байгаль орчны сайд, Эрүүл мэндийн сайд, Түлш эрчим хүчний сайд, Зам тээвэр, аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын сайд, Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч нарт хүргүүлсүгэй.
3. Аудитын тайлангаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2006 оны 10 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Байгаль орчны сайд И.Эрдэнэбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Ц.Батбаяр нарт зөвлөсүгэй.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

Л.ЖАВЗМАА